



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/М/9

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2.1, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт зохицуулалт хийх тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Сумын байгаль хамгаалах, орчны бохирдлыг бууруулах-Хоггүй сум арга хэмжээ”-ний хүрээнд сумын төвлөрсөн хогийн цэгийг шинээр ухаж, хашаажуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Отгонжаргал

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

С.Отгонбаатар

(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Алтансүх

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Ч.Ганхуяг

(Хогны машины жолооч)

Нарийн бичгийн дарга:

О.Отгонбаяр

(Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн)

2.“Сумын байгаль хамгаалах, орчны бохирдлыг бууруулах-Хоггүй сум арга хэмжээ”-ний хүрээнд сумын төвлөрсөн хогийн цэгийг шинээр ухаж хашаажуулах ажилд 19,000,000 (арван есөн сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх ажид хяналт тавин тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА